

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2019 оны 10-р сарын 22-ны өдөр хуралдаж шагналын тухай, “Аймгийн эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөр” батлах тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2019 оны 10 сарын 17-ны өдөр “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл, Ихтамир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын жишиг дэгийн хэлэлцүүлгийг зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт Ихтамир сумын ИТХ-ын төлөөлөгчид 27, “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн менежер, зохицуулагч, Архангай, Ховд, Баян-Өлгий, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нар оролцсон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 10-р сарын 25-ны өдөр 09.00 цагт аймгийн ЗДТГ-ын Хурлын танхимд зохион байгууллаа.

Зөвлөгөөнийг өргөтгөсөн байдлаар зохион байгуулж аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн амчит аж ахуйн нэгжийн дарга, сумдын Засаг дарга, аймгийн төвийн сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар оролцлоо.

Энэ удаагийн шуурхай зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргаас удирдах ажилтнуудад цаг үеийн шинжтэй 10 үүрэг даалгавар өгсөн байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлтийн талаар

Тайлант сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 100.0 хувьтай байна.

Тайлант хугацаанд 22 иргэн, аж ахуйн нэгжид тендерт оролцох виз хүссэн, зээл авах, бусад төрлүүдээр лавлагаа тодорхойлолт гаргаж, цахимаар ирүүлсэн тайлан засварлах, хуулийн хугацаа сунгуулах, тоон гарын үсэг авах зэрэг 153 хүсэлтийг тайс системээр хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд нэг цэгийн өрөөгөөр давхардсан тоогоор 55 гаруй иргэнд зөвлөгөө өгсөн байна.

Хяналт шалгалтын тасаг 10 дугаар сард төлөвлөгөөт 6, төлөвлөгөөт бус 4 татвар төлөгч, өмнөх сарын 2 татвар төлөгч нийт 12 татвар төлөгчийг шалгахаас 10 татвар төлөгчийг шалгаж дууссан 2 татвар төлөгч шалгагдаж байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 12 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтад бүрэн хамруулна. Зөрчил илэрсэн 7 таван татвар төлөгчид Зөрчлийн хуулийн дагуу 258177.4 мянган төгрөгийн зөрчилд 38102.9 мянган төгрөгийн төлбөр ногдуулсан шийтгэлийн хуудсыг татвар төлөгчид зөвшөөрч гарын үсэг зурсан байна. Тайлант сард маргаантай акт буюу шийтгэлийн хуудас байхгүй, 12 татвар төлөгчтэй холбоотой 24

хөндлөнгийн мэдээлэл цуглуулахаас 25 мэдээлэл цуглуулж мэдээллийн санд бүртгэлээ. Хөндлөнгийн мэдээлэл ашиглаж илрүүлсэн зөрчил байхгүй байна.

Өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

2019 оны 10 дугаар сард орон нутгийн өмчит 79 төсөвт байгууллагад 274.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 8 төсөвт байгууллагад 450 нэрийн 80.17 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Орон нутгийн өмчийн газраас худалдан авалтын талаар дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр 200.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 155.6 сая төгрөг, Захиалгат хөрөнгө оруулалтаар 110.3 сая төгрөгний өртөг бүхий 8 төсөл арга хэмжээний худалдан авалтын тендерийн баримт бичиг, урилга, шалгуур нөхцөл, үзүүлэлтүүдийг холбогдох заавар журмын дагуу боловсруулан олон нийтэд ил тодоор худалдан авах ажиллагааны цахим сайт www.tender.gov.mn-д байршуулж, 95 тендер шалгаруулалтын үр дүнг мэдээлснээр тендер ил тод, шударга, хариуцлагатай, хэмнэлттэй үр ашигтай байх зорилгыг хангаж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Улсын бүртгэлийн чиглэлээр

2019 оны 10-р сарын 25-ны байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 1386 бүртгэл хийж гүйцэтгэлээ.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 179
- Гэрлэлтийн бүртгэл - 51
- Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 2
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 4
- Эцэг тогтоосны бүртгэл- 3
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 7
- Нас баралтын бүртгэл - 51
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 121
- Дахин олгосон - 73
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 210
- Үндэсний энгийн гадаад паспорт- 67
- Шилжилт хөдөлгөөн - 114
- Иргэнд - 467 лавлагаа
- Хууль хяналтын байгууллагад - 37 лавлагаа

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:

2019 оны 10 дүгээр сарын 25-ны байдлаар нийт эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл 603 мэдүүлгийг хүлээн авч дараах бүртгэлийг хийж гүйцэтгэлээ.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 57
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 19
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 3
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 122

- Арилжааны гэрээ – 1
- Худалдах худалдан авах гэрээ – 46
- Бэлэглэлийн гэрээ – 5
- Барьцааны эрхийн бүртгэл – 318
- Өв залгамжлал – 9
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 2
- Лавлагаа – 5
- Бусад эрхийн бүртгэл – 16

Хууль хяналтын байгууллагад 55 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 3321167 тэмдэгтийн хураамжид 196369 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 11607550 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн чиглэлээр

- Шинэ-7
- Өөрчлөлт-10
- Тамга тэмдэгтийн хяналтын дугаар олгосон-10

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас тухайн сард төлөвлөгөөт шалгалт 11, төлөвлөгөөт бус шалгалт 3, гүйцэтгэлийн хяналт 11, зөвлөн туслах ажил 8, урьдчилан сэргийлэх арга хэмжээ 9 удаа тус тус зохион байгуулсан байна.

Шүүхийн шинжилгээний албанаас 10-р сард криминалистикийн шинжилгээ 3, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 96, шүүх эмнэлгийн шинжилгээ 89, тусгай шинжилгээ 40-г тус тус хийсэн байна.

10-р сард аймгийн хэмжээнд объектын гал түймрийн зөрчлийн дуудлага 2, объектын гал түймрийн дуудлага 2, ой хээрийн түймрийн дуудлага 1 удаа тус тус ирсэн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/474 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг 9-р сарын 26, 27-ны өдрүүдэд Архангай аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааг хийлээ. Тойм судалгаа хийснээр 19 сумын Гамшгийн эрсдэлийн түвшинг анхан шатанд тодорхойлж, аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсрууллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр

Дэлхийн багш нарын 25, Монголын багш нарын 53 дахь өдрийг тохиолдуулан Архангай аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Эрдэнэбулган сумын 2-р сургууль хамтран Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн дунд 6 төрөлт тэмцээнийг 10 сарын 4-6-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг тэмцээний зорилго нь аймгийн Боловсролын байгууллагуудын дунд спортын шилдэг сургуулийг тодруулах, аймгийн багш нарын шигшээ баг тамирчдыг бүрдүүлэх, харилцан суралцах, баг тамирчдын амжилтыг ахиулах, хамт олны эв нэгдлийг хангахад оршсон болно. Нийт цэцэрлэгийн 32 баг, сургуулийн нийт 23 нийт 57 баг оролцов. ЕБС-иудын дунд зохион байгуулсан тэмцээнд багийн дүнгээр 1-р байрыг Эрдэнэбулган сумын 5-р сургууль тэргүүлж “Шилдэг сургууль”, цэцэрлэгийн төрөлд 1-р цэцэрлэг тэргүүлж “Шилдэг хүүхдийн цэцэрлэг” өргөмжлөл хүртэв.

Соёл урлагийн чиглэлээр

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 40 уншигч шинээр бүртгэж, 1700 ирэгсэдэд 2500 ном, сонин, сэтгүүлээр, хүүхдийн уншлагын танхимаар 99 уншигч шинээр бүртгэж, 2036 ирэгсэдэд 3162 номоор, гэрээр ном олгох үйлчилгээгээр 80 ирэгсэдэд 96 ном, 102 сонин, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 10 уншигч шинээр бүртгэж, 50 ирэгсэдэд, 100 номоор тус тус үйлчилсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлж, орон нутагт ном унших хөдөлгөөнийг өрнүүлэх, ард иргэд хүүхэд залуусын ном унших хүсэл сонирхолыг хөхүүлэн дэмжиж зөв, оюунлаг, эх оронч үзэл санаатай монгол иргэнийг төлөвшихөд дэмжлэг үзүүлэх зорилгоор " Уншлагыг дэмжье" уриатай "Номын баяр-2019" арга хэмжээг 2019 оны 10-р сарын 19-ны өдөр "Ном" сэдэвт дүрийн тоглолт, "Би уншсан номоо зурах дуртай" гар зургийн уралдаан, "Номонд бичсэн захидал" захидлын уралдаан, "Ном дотор зам бий" сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, "Үлгэрийн баатрууд амилсан нь" маск парад гэсэн төрлүүдээр амжилттай зохион байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

2019 оны 10 сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 888 иргэн бүртгэлтэй байгаагаас 467 эмэгтэй, Байнгын шинэ ажлын байр 687, түр ажлын байр 201, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 766, зуучлал 731 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 252 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 6, бага-32, суурь-163, бүрэн дунд-521, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 18, тусгай мэргэжлийн дунд-17, Дипломын бакалаврын-130, магистр-1 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Шинэ ажлын байрыг эдийн засгийн салбараар нь ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 284, боловсруулах үйлдвэрлэлд 271, Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 27, бусад салбарт 306 ажлын байр шинээр бий болсон байна. Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 278, боловсруулах үйлдвэрлэлд 30, барилга 43, үйлчилгээний болон бусад салбаруудад 380 иргэн зуучлагдан орсон байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 9 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч ЭМНДХэлтэс рүү хүргүүлсэн.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг эрх бүхий сургалтын байгууллага болох Монголын хүний нөөцийн менежментийн холбоо ТББ-ийн дэргэдэх Хөдөлмөрийн бирж, Дарь овооны эзэд ТББ-тай гэрээ байгуулан хамтран ажилласан. Ганцаарчилсан зөвлөгөөг ажилгүй болон хүнсний талонд хамрагдаж буй 298 иргэнд, бүлгийн сургалтыг ЕБС-н ахлах ангийн 600 сурагчдад мэргэжил сонголтын талаар зөвлөгөө мэдээлэл өгч сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын санд 2019 оны 10 дугаар сарын байдлаар нийт 12,3 тэр бум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 110 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 15,4 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 40,04 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 4173,7 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Монгол Улсын Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ойн зурвас, төв суурин газрын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны А/202 дугаар “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулах тухай” захирамжийг гаргуулан холбогдох байгууллага, албан тушаалтанууд хамтран хэрэгжилтийг ханган ажиллаж “Мод тарих аян”-ыг аймгийн БОАЖГ-аас Сум дундын ойн анги, сумдын Засаг даргын Тамгын газруудтай хамтран 2019 оны 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа.

Энэ намрын мод тарих аяны хүрээнд нийт 12058 ширхэг мод, бут сөөг таригдсан байна. Үүнээс 5509 ширхэг мод, 6549 ширхэг бут сөөгийг 106 аж ахуйн нэгж, байгууллагын 1805 иргэд тарьж цэнэг усалгаа болон амгаалалтын ажлыг хийлээ.

Архангай аймгийн хэмжээнд 9-р сарын 01 нээс 30-ны хооронд Хоггүй Архангай уриатайгаар намрын хог цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа.

Бүх нийтийн цэвэрлэгээнд нийт 394 албан байгууллага, аж ахуйн нэгж, 7758 ажилтан албан хаагч, иргэд, 8–12 дугаар ангийн сурагч оролцож 2660.6 га нийтийн эзэмшлийн зам талбай, 138 км голын голдирол, 158,5 км улсын чанартай авто зам болон орон нутгийн зам дагуу цэвэрлэн 1888,5 тн хог хаягдал ачиж зайлууллаа.

Барилга, дэд бүтцийн чиглэлээр

Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж 9 дүгээр сард дараах барилгын их засварын ажил болон барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтанд хүлээн авсан байна. Тухайлбал: Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн спорт залны засвар, Хашаат сумын 75 ортой хүүхдийн дотуур байрны дээврийн засвар, Тагнуулын ерөнхий газрын албан конторын барилга угсралт, Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засвар өргөтгөл, Төвшрүүлэх сумын Хаан банкны тооцооны төвийн барилга, Цэвэрлэх байгууламжын барилга, Нэгдсэн эмнэлгийн засвар, Өндөр-Улаан сумын Соёлын төвийн барилгын засвар, Мобикомын гэрлэн цамхагтай үүрэн холбооны станц, 1,2-дугаар 48 айлын орон сууцны авто зогсоол зэрэг ажлууд дээр улсын комисс ажиллан байнгын ашиглалтанд хүлээн авсан байна.

